



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн,  
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 4.5.1 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын техник, технологийн зөвлөлийн хурлын 2021/2 дугаар шийдвэр, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.1.1, 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нислэгийн хөдөлгөөний удирдлагад ашиглагдаж буй AIRCON 2100 системийн үйл ажиллагааны доголдлыг арилгах, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг сайжруулах, техникийн туслалцаа авах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн ажлын явцыг тогтмол илтгэж, тайлан дүгнэлтийг 2021 оны 02 дугаар сарын 12-ны өдөрт багтаан танилцуулахыг ажлын хэсэг /Э.Төрбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ




Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын  
2021 оны 01 дүгээр сарын 28 -ны өдрийн  
А/13 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Э.Төрбаяр	Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:	Х.Идэрмаа	Холбоо, навигаци, ажиглалтын албаны гадаад харилцааны мэргэжилтэн
Ажлын хэсгийн гишүүд:	П.Ганболд	Иргэний нисэхийн ерөнхий газрын Төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга /тохиролцсоноор/
	У.Өнөрцэцэг	Хууль, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга
	Д.Уртнасан	Агаарын навигацийн бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	З.Туяа	Хуулийн хэлтсийн дарга
	Д.Түвшинбаяр	Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын Агаарын харилцааны тасгийн дарга /тохиролцсоноор/
	Э.Энхмөнх	Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын техникийн бодлого хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/
	Б.Мөнхзул	Иргэний нисэхийн ерөнхий газрын Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын хуулийн мэргэжилтэн /тохиролцсоноор/

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын  
2021 оны 02 дүгээр сарын 12-ны өдрийн  
А/13 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ



### **Нэг. Зорилго**

Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автоматжуулалтын AIRCON 2100 системийн найдвартай хэвийн ажиллагааг хангах, сайжруулах, техникийн туслалцаа авах ажлыг зохион байгуулахад оршино.

### **Хоёр. Хэрэгжүүлэх арга хэмжээ**

Ажлын хэсэг нь тушаалаар заагдсан хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автоматжуулалтын системийн талаарх судалгаа хийх, ижил төстэй систем бүхий гадаад орнуудын нислэгийн хөдөлгөөн удирдах төвүүдтэй холбоо тогтоох, туршлага судлах,

2. Үйлдвэрлэгчтэй системийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх талаар хамтран ажиллаж байсан байдал, үйлдвэрлэгч компаниас тухайн системийн найдвартай хэвийн ажиллагааг хангах, сайжруулах талаар зөвлөгөө авах, хамтран ажиллах, холбогдох мэдээлэл, саналыг нэгтгэн боловсруулах,

3. Үйлдвэрлэгч компаниас ирүүлсэн санал болон бусад судалгааны дүгнэлтийг үндэслэн автоматжуулалтын AIRCON 2100 системийн найдвартай хэвийн ажиллагааг хангах, сайжруулахад чиглэсэн санал боловсруулах,

### **Гурав. Хүрэх үр дүн**

Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автоматжуулалтын системийн аюулгүй ажиллагаа, тасралтгүй, найдвартай байдлыг дээшлүүлэх хэмжээнд санал боловсруулагдсан байна.

### **Дөрөв. Тайлагнах**

Ажлын хэсгээс гаргасан тайлан дүгнэлтийг Иргэний нисэхийн үндэсний төвийн даргад 2021 оны 02 дугаар сарын 12-ны өдөрт багтаан танилцуулна.